



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 5.1.3, 11.2, 14.2.3, 14.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны "Олон улс, улсын чанартай авто замын чиглэл батлах тухай" 144 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Улсын чанартай "А" ангиллын авто замуудын чиглэл, дугаар, эхлэх төгсөх цэгийн нэрсийн жагсаалт"-д

№	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын дугаар	Замын эхлэх төгсөх цэгийн нэрс	Замын урт /км/
33	A33	A33	Баян-Уул- Эрээнцав	269

гэж нэмсүгэй.

2. Шинээр авто замын чиглэл нэмсэнтэй холбогдуулан дээрх жагсаалтын улсын чанартай авто замын нийт урт "12648" гэснийг "12917" гэж өөрчилсүгэй.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан шинээр улсын чанартай авто замын ангилалд шилжүүлсэн A33 дугаартай авто замын арчлан хамгаалагчийг тогтоох, төсвийг хуваарилж, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, Санхүү, эдийн засгийн хэлтэс /З.Цэрэнчимэг/-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /П.Билгүүн/-т үүрэг болгосугай.

САЙД



М.ЗОРИГТ